

талаар Даосын сурталт бомбо нар күнз, мэнзийнхээс нилээд талаар илүү байсан билээ.<sup>5</sup>

Гэвч энэ байдлыг ялангуяа тэр үед Монгол шиг харь газрын нүүдэлчин малчдын зүгээс ойлгон мэдэхэд үнэхээр бэрх байсан юм. Гэтэл Чингис хаан хэргийн учрыг тоймлон мэдэж Даосын ёс, Чан Чүнь бомбыг дэмжин тэтгэсэн байна. Тэр үеийн хятадын олон суртал дотроос чухамхүү материалист гарал язгуур бүхий Даосын ёсны чадалтай талыг тийн мэдэж, үй түмэн хушан, бомбо нарын дундаас наран хиртэх нарийн учрыг зөв ойлгосон Чан Чүнь шиг их эрдэмтнийг сонгон олж чадсан нь Чингис хааны зүгээс алив юмны учрыг ухан ойлгох, ялангуяа хүний чанар чансааг танин мэдэж, зохих байрыг зөв эзлүүлэн хэрэглэж чаддаг төрийн их хүний ховор нандин чадвар бүхий явдал нэг бус удаа илэрсний тодорхой баримт мөн бөгөөд Чингисийн тийм хурц авьяас, мэргэн хараа нь монголын тулгуур төр үүсэн мандахад ямар ч хүний хичнээн ч их цэргийн чадвараас дутуугүй үүрэг гүйцэтгэсэн болохыг тэмдэглүүштэй.

1. E. Bretshneider M. D. Medieval researches from eastern Asiatic sources, Vol 1, London, 1910, 35-р тал
2. Эртний Хятадын төрийн хамгийн дээд тушаалын түшмэд сайдуудыг тэгж нэрлэдэг байсан юм.
3. 1215 онд Алтан улсыг байлдсан тухайгаа ярьж байна.
4. Монголын нууц товчоон, Ц. Дамдинсүрэн 250-р тал.
5. Ян Хин шүн. Древне-китайский философ Лао-Цзы и его учение. М-Л., 1950

**БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД БОДЛОГЫН ТУХАЙ  
(1911—1919)**

**Ц. Пунцагноров\***

VIII Жавзундамба хутагтын улс төрийн үзэл бодол манжийн Дайчин гүрнээс XIX зууны хоёрдугаар хагасаас Монголд «шинэ бодлого» явуулсан үед бүрэлдэн тогтсон юм. «Шинэ бодлого» гэгч нь эцсийн бүлэгт Монголын үндэсний гал голомтыг унтраахад чиглэснийг хутагт ойлгож манжийн ноёрхлоос ангижирч үндэсний тусгаар тогтнолыг сэргээх арга замыг хайж эхэлсэн юм. Тэгэхдээ гаднаас авах дэмжлэгийг онцгой анхаарч байжээ. Тэрээр Монгол орон хоёр том гүрний хооронд оршдог болохоор тусгаар тогтнолоо тэмцэн олох, түүнийг батлан хамгаалахад умард хөрш-хаант Орос улсын дэмжлэг зайлшгүй хэрэгтэйг гүнзгий ухамсарлажээ.

Богд гэгээн 1895 онд Их Шавийн даа лам Бадамдоржийг Орос улсад нууцаар явуулж Цагаан хаанд бараалхуулан Монгол орныг Манжийг захиргаанаас гаргаж тусгаар улс болоход нь Чин улсад зуучлахыг хүсчээ. Хэрэв манж нар Монголын тусгаар тогтнох эрмэлзлийг хүч хэрэглэн дарахыг завдвал Оросоос цэргийн тусламж гуйна гэжээ. Тусгаар тогтносон Монгол улсын нутаг дэвсгэрийн өмнө зах хязгаарыг цагаан хэрмээр тогтоож монголчуудын эртний нутгийг бүрэн эзлүүлэх бодолтой байжээ.

\*ШУА-ийн гишүүн, Энэ илтгэл нь 1992 оны 8 сард хуралдсан Олон улсын Монголч эрдэмтдийн VI их хуралд тавигдсан бөгөөд зохиогчийн хүсэлтээр бүрэн эхээр нь нийтлэв. Илтгэлд тусгагдсан үзэл бодол зөвхөн зохиогчийн бөгөөд сэтгүүлийн редакцийн биш гэдгийг уншигчид болгооно бизээ.

Богд гэгээний эдгээр санаа хожим тусгаар тогтнолоо зарласан монгол улсын гадаад бодлогын үндсэн чиг баримтлал болсон билээ.

XX зууны эхээр манжийн дарлалыг эсэргүүцсэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ар, өвөр Монгол даяар өрнөх нийгмийн бүх давхраа хар, шар, ард, тайж, засаг ноёд, хутагт хувилгаадыг хамарчээ. Ийм нөхцөлд эдийн засаг, үзэл суртлын асар их хүчтэй ламын сүм хийдийг толгойлсон Богд гэгээний улс төрийн нөлөө эрс өсч тусгаар тогтнолын төлөө тэмцлийг нэгтгэн зангидах хүчин зүйл болов.

1911 оны 7-р сард болсон ноёд, дээд лам нарын ээлжит чуулганаар манжийн шинэ бодлогыг хэлэлцэхэд чин ван Ханддорж нар Орос улсын тусламж олж Манжаас тусгаарлах санал гаргахад нийтээр болгоон зөвшөөрч Орос улстай хэлэлцээ хийх төлөөлөгчдийг Петербургт нууцаар явуулжээ.

Төлөөлөгчид Орос улсаас нааштай хариу авч ирмэгц Богд гэгээнээс монголчууд тусгаар улс байгуулах цаг нэгэнт болсон тухай лүндэн буулгажээ. Манжийн захиргааны эсрэг зэвсэгт бослого зохион байгуулах «Халхын хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн шийтгэх газар» байгуулагдаж 1911 оны 12-р сарын 1-нд Монголын тусгаар тогтнолыг тунхаглажээ. Уг тунхаг бичигт: Манай Монгол болбаас угтаа тусгай нэг улс мөн тул одоо хуучин журмаар өвсөөвэн улс болон өөрийнхөө хэргийг бусдаар эрхлүүлэхгүй шинэ төр байгуулж тогтоохоор зөвлөн тогтсон» гэжээ.

Хүрээнд татаж ирүүлсэн монгол цэргийн хүчинд тулгуурлан манжийн сүүлчийн амбаныг тус орноос хөөн зайлуулаад мөн сарын 16-нд Богд гэгээнийг Монгол улсын шашин төрийг хослон барьсан хаанаар өргөмжлөх ёслол хийжээ. Жавзундамба хутагтыг ийнхүү улсын хаан болгосон нь үндэсний амин чухал асуудлаар монголчуудын хэзээ хэзээний хүсэл мөрөөдлийг тусгасан түүний улс төрийн байр суурьтай холбоотой юм. Хутагтын Ар монгол дахь анхны дүр Чингис хааны удмын Түшээт хааны гаралтай байсан нь түүхийн чухал үндэслэл болсон юм.

Тэр үед Их хүрээнд сууж байсан Орос улсын консул В. Ф. Люба Богд гэгээнийг Манжаас тусгаарлах тэмцлийг «манлайлсан хүн», «санаанд багтамгүй үйл хэргийг хэрэгжүүлж чадсан» гэж үнэлсэн байна.<sup>1</sup>

Богд гэгээн Монголын хэмжээгүй эрхт хаан болсныхоо дараа тусгаар тогтнолын төлөө тэмцэлд идэвхтэй оролцон Ар, Өвөр Монголын хар, шар феодал, мэргэн сайд, цэргийн гарамгай жанжнуудаар биеэ хүрээлүүлсэн нь Монголын шинэ төрийг бэхжүүлэхэд үлэмж чухал үүрэг гүйцэтгэжээ. Дилав хутагт Жамсранжав дуртгалдаа Богд хааныг маш чадвартай улс төрийн бодлоготон гэсэн байна.<sup>2</sup> Монгол улсын гадаад бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхэд чин ван Ханддорж, даа лам Цэрэнчимэд, Өвөр Монголын гүн Хайсан, Сайн ноён хан Намнансүрэн, хичээнгүй сайд, гүн Цэрэндорж гэх зэрэг зүтгэлтнүүд голлон оролцсон болно.

Богд хаант улсын гадаад бодлого юуны өмнө Орос оронтой тогтоосон харилцаа холбоогоо бэхжүүлэхэд чиглэжээ. Энэ зорилгоор 1912 онд Нийслэл Хүрээнд Монгол-Оросын хэлэлцээ хийхэд Монголын тусгаар тогтнолын асуудлаар хоёр улсын хооронд зарчмын санал зөрөлдөөн байсан нь тодров. Богд хааны засгийн газар, Ар, Өвөр Монголыг нэгтгэсэн бүрэн эрхт улс байгуулахыг зорьж байхад хаант Орос улс дан Ар монголыг автономит улс болгох санаатай байв. Хэлэлцээний үеэр ширүүн маргаан өрнөж Оросын төлөөлөгч, элчин Коростовецын бичсэнээр: **«Монголын засгийн газар бусад гүрнүүдээс огт тусгаар байхыг**

**шаардаж байв»<sup>3</sup>**. 1912 оны 11-р сарын 5-нд гарын үсэг зурсан Орос Монголын гэрээгээр хаант Орос улс Монголыг үндэсний цэрэг байгуулах, хятадын цэрэг, суурьших гэсэн иргэдийг өөрийн нутагт оруулахгүй байх эрх бүхий автономит улс хэмээн хүлээн зөвшөөрчээ. Мөн Оросын хөрөнгөтнүүд Монголын эдийн засагт өргөн нэвтрэх бололцоо олж авчээ.

Богд хаан Монголын бүрэн эрхт тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх, Ар, Өвөр Монголыг нэгтгэх бодлогоо шаргуу үргэлжлүүлж засгийн газрын төлөөлөгчдийг Петербургт удаа дараа явуулж дэмжлэг олох гэж оролдсон боловч хаант Орос улс татгалзаж зөвхөн Ар Монголыг Хятадын түрэмгийллээс хамгаалахад зориулан зэвсгийн тусламж үзүүлсэн байна.

Хэдий тийм боловч Монгол орон хоёр зуу гаруй жил ноёрхсон манжийн дарлалыг түлхэн унагаах, Хятадын эзлэн түрэмгийлэх гэсэн оролдлогыг хаант Орос **улсын туслалцаатай няцааж чадсан нь** Богд гэгээний гадаад бодлогын үндсэн чиг баримтлал зөв зүйтэй байсныг гэрчилж байна.

Богд хаан, өмнөд хөрш-Хятад улстай хэвийн харилцаа тогтоох гэж чармайсан боловч тэр нь явцгүй байв. Үүний шалтгаан: Хятад улс өөрийгөө манжийн Чин улсын өв залгамжлагч гэж үзээд таван угсаатны (Хятад, Манж, Монгол, Түвд, Лалын шашинтан) Бүгд Найрамдах улс байгуулах нэрийдлээр Монголыг Хятадтай нийлүүлэх түрэмгий бодлого явуулсантай холбоотой юм.

Хятадын ерөнхийлөгч Юань Шикай элдэв шан харамж амлан Богд хааныг биедээ татахыг оролдож байлаа. Гэвч ийм аргаар Богд хааныг Монголын тусгаар тогтнолоос татгалзуулж чадсангүй. Богд хаанаас Юань Шикайд явуулсан захидал, цахилгаанд Монголыг Хятадтай нийлүүлэх гэсэн бодлого түүхийн ямар ч үндэсгүй гэдгийг баримт нотолгоотой харуулахын хамт хоёр улсын хооронд найрамдалт харилцаа тогтоохыг санал болгож байв. Тухайлбал, олноо өргөгдсөний хоёрдугаар он, өвлийн сүүл сарын еснөө (1912) Богд хаанаас Хятадын ерөнхийлөгчид илгээсэн нэгэн захидалд өгүүлсэн нь: «Манай хоёр улс бол цөм урьд Чин улсын түшмэл ард мөн. Чин улсын засгийн явдлыг сайнаар явуулаагүйн тул тус тусдаа цагийн улирлыг дагаж өөртөө улс байгуулж өөр өөрийн ардаа эзэлсэн байна. Эрхэм танаа (Та) иргэн хүний эзэн болж би монгол хүний эзэн болж; ...Миний улс байгуулсан нь эрхэм таны улс байгуулсанаас урьд ажээ. Харилцан өшөөтэй байх ёсгүй мэт»<sup>4</sup> гэжээ. Захидлын төгсгөлд Хятад улсын эрх баригчид хандаж: «Хэрэв цэрэг хэрэглэхэд хүрвэл алин этгээдийн хүн, эд дэмий хохирон олныг зовоон гасалгах нь магад. Хэний этгээд дийлэх, дийлэгдэх нь бурхан тэнгэрийн туслалд бийгээс бус хүний санаагаар үл болно. Жич: Эрхэм Танаа бодсон дээрээ бодохыг сануулна. Үүний тулд их амрыг эрж хариу өгөхийг хүсье. Монгол улсын хаан ёслол»<sup>5</sup> гэжээ.

Хятад улс Монголын тусгаар тогтнолыг устгах бодлого явуулах болсоныг харгалзан Богд хааны засгийн газар Өвөр Монголыг хамгаалах зорилгоор таван замаар цэрэг хөдөлгөж Хятадын түрэмгий цэрэгтэй байлдааны ажиллагааг амжилттай явуулсан билээ. Гэвч хаант Оросын шахалт, шаардлагаар удахгүй цэргээ гэдрэг татахад хүрсэн байна. Хятадын цэргийн эрхтнүүд Монголын хил хязгаарын дагуу үлэмжхэн тооны цэрэг бөөгнөрүүлсэн боловч мөн хаант Оросын сануулга, сүр хүчнээс эмээн Ар Монголын нутагт дайралт хийгээгүй билээ.

Өрнөдийн болон Азийн зарим оронтой албан ёсны харилцаа тогтоох явдал Богд хааны гадаад бодлогын чухал хэсэг байв. Энэ зорилгоор Монголын засгийн газар Англи, Франц, АНУ, Герман, Япон, Австри, Голланди, Бельги, Дани улсуудын засгийн газар хандаж «Гэрээ байгуулан худалдаа нэвтрүүлж улсын найрамдлыг зузаатгах» санал тавьжээ. Монголын засгийн газрын төлөөлөгчдийг Өрнөдийн орнууд болон Японд явуулах гэсэн боловч хаант Орос улс саад хийжээ.

Монгол улс Ази тивд ганцхан Түвдтэй харилцан тусгаар тогтнолоо зөвшөөрөх, харилцан туслах тухай гэрээнд 1913 оны 1-р сарын 1-нд гарын үсэг зуржээ. Далай ламын засгийн газартай байгуулсан энэ гэрээ Богд хааны улс төрийн нэр хүндийг өргөснөөс гадна хоёр орны эрх баригчид гаднын даралт шахалтын эсрэг эв санааны нэгдэлтэй байгааг илтгэн харуулжээ. Гэвч Англи улс хөндлөнгөөс оролцож энэ гэрээг удахгүй цуцалжээ.<sup>6</sup>

Өрнөдийн гүрнүүд, мөн Япон улс Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөөгүй нь тэр үед колонийн ёс дэглэм дэлхий дахинд хөдөлбөргүй ноёрхож түрэмгий цөөхөн гүрэн бага буурай орнуудыг нөлөөнийхөө хүрээнд хувиарлан захирч тэднийг биеэ дааж амьдрах чадварыг нь үгүйсгэж байсантай холбоотой юм.

Эзэрхэг түрэмгий гүрнүүд хоорондоо тохиролцсон ёсоор Ар Монголыг хаант Оросын нөлөөний хүрээнд оруулсан байв. Ийм ч учраас эцсийн бүлэгт Монголын тусгаар тогтнолын хувь заяаг хаант Орос шийдвэрлэжээ. Ар монголын автономит засгийн тухай Хятад улстай 1913 онд байгуулсан гэрээнд Хятад, Монголын харилцааг «сюзеренитет» (хэмжээтэй эзэрхэх) эрх хэмжээ гэж тодорхойлжээ. Оросын гадаад явдлын яамны сайд Сазонов: «...Хятадаас Монголын хувьд эдлэх сюзеренитет нь... **Монгол улс** бүх асуудлаар, тэр ч байтугай улс төрийн талаар гадаадтай харилцах эрхийг нь үгүйсгэхгүй юм» гэжээ.<sup>7</sup>

**Монгол, Хятадын хооронд** олон сар үргэлжилсэн хурц маргалдаан тэмцлийн дүнд 1915 оны 6-р сарын 7-нд байгуулсан Орос-Хятад-Монгол гурван улсын Хиагтын гэрээгээр Ар монголд автономит эрхийг тулган хүлээлгэжээ. Монгол улс дотоод хэргээ өөрөө бүрэн шийдэх болж бас гадаадтай эдийн засгийн асуудлаар харилцах эрхээ авч үлджээ. Орос, Хятад улсууд автономит Монголыг «олон гадаад улстай... худалдаа ба үйлдвэрийн хэрэг зүйлээр холбогдох олон улсын гэрээ бичиг ба гэрээ зүйлийг тогтоон байгуулах онц эрхтэй» гэж зөвшөөрөн хүлээв. Монголд холбогдох улс төр, газар нутгийн асуудлуудыг Орос, Хятад хоёр хамтарч автономит Монголын төлөөлөгчдийг оролцуулан шийдвэрлэж байхаар тогтоожээ.

Ийнхүү гурван улсын гэрээгээр хаант Орос, Хятад хоёр 1911 онд тунхагласан Монголын тусгаар тогтнолыг цуцлаж **Богд хаант автономит улс** болгожээ. Нэр төдий Хятадын хязгаарлагдмал сюзеренитет эрхийг хүлээсэн автономит Монгол нь хэрэг дээрээ хаант Оросын улс төр, эдийн засгийн бүрэн хяналт, хамгаалалтанд оржээ. Тухайн цаг үедээ бие даасан автономит улс болно гэдэг бол бүрэн эрхт тусгаар тогтнолын зүгт хийсэн томоохон алхам байсан юм.

Монголын гадаад харилцааг аль болох өргөтгөхөд чиглэсэн Богд хааны бодлого тус улсын нийгэм-эдийн засгийн хөгжилд чанарын зарим ахиц өөрчлөлт гарахад түлхэц болсон билээ. Монголын эдийн засаг дэлхийн зах зээлд татагдан орсоны улмаас хамжилгат ёсны задрал түргэсч хүн амын баян чинээлэг хэсэг улам тодорч, ядуурал хоосрол гүнзгийрэв. Нийслэл хүрээ болон бусад хотод лам нараас гадна бичиг, цэргийн түшмэд, гар урчууд, үйлдвэрийн ажилчид, худалдаачид,

панзчин гэх мэт хэсгээс бүрдсэн хотынхны тусгай давхраа үүсч хотын улс төр, худалдаа-эдийн засагт соёлын үүрэг өсөв. Гадаадын хөрөнгөтнөөс байгалийн баялгийг ашиглах уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулах явдал нэмэгдэв. Орчин үеийн тээвэр, харилцаа холбооны зарим төрөл (уурын тэрэг, цахилгаан болон утсан харилцуур) нэвтэрч нийслэл хот цахилгаан гэрэлтэй болов.

Богд хаан төрийн захиргааны үйл ажиллагаанд гаднаас зохион байгуулалтын шинэ шинэ арга хэлбэрийг авч хэрэглэв. Хаант Оросын Думын жишээгээр дэргэдээ зөвлөх эрхтэй Улсын хурлыг хоёр танхимтайгаар байгуулжээ. Голчлон жижиг феодал, бичиг, цэргийн түшмэдээс бүрэлдсэн доод танхим Монгол оронд ардчилсан хувьсгалт үзэл санаа дэлгэрүүлэх нэг эх сурвалж болсон билээ. Мөн Орос улсаас цэргийн мэргэжилтнүүдийг урьж монгол цэрэгт орчин цагийн зэвсэг эзэмшүүлэн байлдааны арга ажиллагаанд сургажээ.

Богд хааны засгийн газар буриадын их эрдэмтэн, соён гийгүүлэгч Жамсрангийн Цэвээнийг урьж гадаад явдлын яамны орчуулагч түшмэл бөгөөд сургуулийн хэргийг туслан шийтгэх түшмэлээр ажиллуулсан байна.

Нийслэл хүрээнд орос, хятад, англи багштай сургууль нээж хошуудад гуч гаруй сургуулийг сангийн болон хувийн хөрөнгөөр байгуулжээ. Хүүхэд, залуучуудыг гадаадын сургуульд явуулж эхлэхийн зэрэгцээ сургууль соёлын ажилд идэвхтэй оролцсон, тусалсан хүмүүсийг зүйл бүрээр урамшуулж байв.

Мөн тэр үед сонин хэвлэл бий болж дотоод, гадаадад болсон үйл явдлын тухай тогтмол мэдээлэл олон нийтийн дунд шинжлэх ухаан, улс төрийн мэдлэг дэлгэрүүлж байсан нь ардчилсан хувьсгалт үзэл санаа бүрэлдэхэд чухал нөлөө үзүүлсэн байна.

Гурван улсын Хиагтын гэрээ байгуулсны дараа Монгол улсын улс төрийн дотоод байдал тогтворгүй болж гадаад бодлогын асуудлаар ноцтой өөрчлөлт гарах хандлага тодров. Энэ нь хар, шар феодалуудын хооронд эрх, засаг булаацалдсан зөрчил тэмцэл хурцадсантай холбоотой юм.

Монголын тусгаар тогтнолын үйл хэргийг үүсгэн зохион байгуулж Орос улсыг түшиглэх чиг шугам баримталж байсан Ханддорж, Намнансүрэн зэрэг зүтгэлтэн улс төрийн тавцангаас аажмаар зайлуулагдаад шанзав Бадамдорж тэргүүтэй Хятадын талыг баримтлагчдын байр суурь бэхжив. Богд хааны үйл ажиллагаа улам бүр зөрчилтэй туйлбаргүй болжээ. Богд хаан нэг талаар дэвшилт үзэлтэй ноёд, дээд лам нар, бичиг, цэргийн түшмэдийн нөлөөгөөр улс орноо шинэчлэн өөд нь татахыг эрмэлзэж нөгөө талаар хуучныг баримтлагч урвамтгай харгис үзэл бодлоготны даралт шахалтанд автагдан Монгол улсын оршин тогтноход аюул занал учруулсан хүчний явууллагыг тууштай эсэргүүцэж чадаагүй юм. Энэ үед Богд хааны дураараа авирлах, ууж согтуурах явдал даамжирчээ.

Октябрийн хувьсгалын дараа Орос оронд иргэний дайн дэгдсэнийг далимдуулан Хятадын эрх баригчид Монголын автономит төрийг устгажээ. Хятадын цэргийн түрэмгийлэл нийт монголчуудын уур хилэнг бадрааж үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг өрнүүлжээ.

Богд гэгээн хятад цэргийн хүчинд буулт хийсэн боловч гадны дэмжлэг олж Монголын үндэсний засаг төрийг сэргээн босгох оролдлогоо идэвхтэй хийсэн юм.

Орос улсад цаг төрийн үймээн болж байсан болохоор хойд хөрш орноос гадна өөр аль нэг орны дэмжлэг олох гэсэн бодол эрмэлзлэл монголын эрх баригчдын дунд хүчтэй болов. Зарим нь ойр бөгөөд түргэнийг нь харгалзан Япон улсаас тусламж гуйх санал гаргахад Богд гэгээн японы цэрэг Солонгосыг эзлэн хэрцгийлсэн хэмээн татгалзсан юм.<sup>8</sup> Жалханз хутагт Дамдинбазар, Дилав хутагт Жамсранжав нар баян бөгөөд хүчирхэг Америк улсаас дэмжлэг авах санал тавихад Богд гэгээн зөвшөөрчээ.

АНУ-ын ерөнхийлөгч В. Вильсон 1918 онд зарласан дэлхийн дайны дараах энх тайвны программдаа бага, буурай орны улс төрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилт дэвшүүлсэн нь тийнхүү Монголын эрх баригчдын найдлага төрүүлсэн бололтой. Монголд ажиллаж байсан Польш улсын (хуучин хаант Оросын) иргэн Воллосович М. А. ерөнхий сайд Намнансүрэнд бичсэн захидалдаа Вильсоны саналын дагуу «бусдын эрх мэдэлгүй тусгаар улс болох» хүслээ АНУ болон Өрнөдийн орнууд түүнчлэн Орос, Хятадын төлөөлөгчдөд мэдүүлж АНУ-ын Конгрессоор Монголын асуудлыг хэлэлцүүлэхийг зөвлөж байсан байна.

1920 оны хавар, зун америкийн дипломат Эберхардт, Сокобин нар Нийслэл хүрээнд ирэхэд Богд гэгээн Монгол улсыг сэргээхэд АНУ-ын тусламж хүссэн бичгийг тэдэнд өгүүлсэн байна.

Хятадын ерөнхийлөгчид талархал илэрхийлэх нэрийдлээр Бээжинд явуулсан Жалханз хутагт тэргүүтэй төлөөлөгчид чухамдаа Монголын автономитийг сэргээх хүсэлт тавих ёстой байв. Үүний зэрэгцээ төлөөлөгчид АНУ-ын дипломат төлөөлөгчидтэй уулзаж дэмжлэг авах тухай хэлэлцээ хийх үүрэгтэй байжээ. Жалханз хутагт Бээжин дахь АНУ-ын элчинтэй уулзаж Богд гэгээний хүсэлтийг дамжуулахад засгийн газартаа уламжлана гэсэн улигт хариуг өгчээ. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орсон Дилав хутагт америкийн цэргийн аташед Монголын хүсэлтийг давхар тайлбарлан танилцуулжээ.

Энэ үед Хятадын түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцэл улам бадарч тэмцлийн явцад үүссэн ардын хувьсгалт байгууллага Зөвлөлт Орос улсаас тусламж авах аргыг сүвэгчилж байв.

Богд гэгээн Монголын үндэсний төрийг сэргээхэд америкийн дэмжлэгийг нэгэнт хүссэн болохоор Зөвлөлт Орос улсаас тусламж гуйхыг хойшлуулсаар байв. Гэвч АНУ ямар нэгэн хариу өгөөгүй учир Богд гэгээн даа лам Пунцагдоржоос оруулсан Зөвлөлт Орос улсаас гуйсан ардын намынхны бичигт 1920 оны 8-р сард гарын үсэг зурж, тамгаа даржээ.

1921 оны 7-р сард ардын хувьсгал ялж тусгаар тогтносон Монгол ард улсыг тунхаглан Богд гэгээнийг хэмжээт эрхт хаанаар өргөмжил-

1. Архив Внешней политики России, Фонд миссии в Пекине, дело № 316
2. Diluv Khutagt. Memoirs and autobiography. Wiesbaden 1982, p. 161
3. Ц. Пунцагноров. Монголын автономит үеийн түүх, УБ, 1955, 54-р талд
4. БНМАУ Түүхийн төв архив, Ф. А. 173, т. 1, х. 3
5. БНМАУ, Улсын түүхийн төв архив. ф. 173, т. 1, х. н. 1
6. Ц. Пунцагноров. Монголын автономит үеийн түүх. УБ, 1955, 59-р талд
7. Сборник дипломатических документов по монгольскому вопросу СПб, 1914, стр. 90
8. Diluv Khutagt. Memoirs and autobiography. Wiesbaden. 1982, p. 91
9. БНМАУ-ын түүхийн төв архив. Ф1—4, т. 1, х/н 521

жээ. Ийнхүү Монгол улсын түүх, Богд хааны амьдрал, үйл ажилд чанарын шинэ үе эхэлжээ.

Богд хаант улсын гадаад бодлогын ерөнхий чиг баримтлал ардын засгийн үед ч уламжлагдан шинэ агууллагаар баяжин хөгжсөнийг эцэст нь тэмдэглэж хэлье.

## **ӨВӨР МОНГОЛ ДАХЬ МОНГОЛ ТҮҮХ СУДЛАЛЫН ТОЙМ**

**Хэрээд. Л. Жамсран\***

Монгол, Хятад хоёр улсын харилцаа хэвийн болж, тус бүрдээ нээлттэй бодлого явуулсны ачаар хоёр орны хамтын ажиллагаа шинэ хэлбэрүүдээр хөгжин гүнзгийрч бүхийд ШУА-ийн Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн ажилтан бид хоёр хүн Өвөр Монголын Их Сургуулийн монголын ойр ба орчин үеийн түүх судлах тэгш солилцооны газарт тэгш солилцооны эрдэм шинжилгээний томилолтоор 1992 оны сүүлчээр очиж цөөн хоног ажиллав. Тэгэхэд мэргэжил нэгт Өвөр Монгол нөхөд биднийг номын санд ажиллах түүхийн дурсгалт газраар тойрон аялах зэрэгт ах дүүгийн халуун сэтгэлээр туслаж байлаа. Өмнөт Монгол буюу Өвөр Монгол нь зөөлөн уур амьсгалтай тул дээр үеэс мал аж ахуйн зэрэгцээгээр тариалан түлхүү эрхлэн суурьшиж эхлэсэн бөгөөд хүн амын тоогоор ч монгол угсаатны олонхи билээ. Шарын шашин Өвөр Монголд эхлэн дэлгэрч улмаар монголын бусад хэсэгт дэлгэрсэн, Монголын бичгийн мэргэд эрх чөлөөний төлөө тэмцэгчид мөн энэ нутгаас цөөнгүй төрсөн. Түүхийн таагүй нөхцөлд эх хэл, бичиг, түүх соёлоо нандигнан хамгаалж хадгалж ирсэн Өвөр монголчууд өөрчлөлт шинэчлэлийн одоо үед аж амьдралаа үзэгдэхүйц сайжруулж эдийн засаг, соёлын талаар чамгүй амжилт олж буйг нүдээрээ үзэв. Хэдүй тийм боловч тэр бүхнийг үл өгүүлэн харин өөрийн уншсан, мэргэжил нэгт нөхдөөс сурвалжилж мэдсэнээ үндэслэн Өвөр Монгол дахь өөрчлөлт шинэчлэлийн нэг хэсгийг энэхүү өгүүлэлд тойм төдий бичиж уншигч олондоо толилуулая.

### **Нэг. Монгол түүх судлалын гол байгууллагууд**

Монголчууд эх түүхээ судлаж бүтээл туурвиж ирсэн уламжлалтай. Түүнд Өвөр Монголчууд чухал суурь эзлэдэг боловч үндэсний ардчилсан хувьсгал ялж Өвөр Монголын өөртөө засах орон (ӨМӨЗО) байгуулагдсан түүхийн шинэ нөхцөлд Монгол түүхээ тусгайлан судлах ажил 50-аад оны үеэс эхлэсэн агаад 1958 онд Өвөр Монголын түүх судлах газар (институт), олон нийтийн эрдэм шинжилгээний байгууллага «Өвөр Монголын түүхийн нийгэмлэг» байгуулагдаж монгол түүхээ судлах ажил эрхлэх болсон юм. Мөн оноос Өвөр Монголын Их сургууль, Өвөр Монголын багшийн дээд сургуульд монгол түүх судлах тасаг байгуулагдан ажиллаж эхлэсэн боловч БНХАУ-д болж байсан улс төр, үзэл суртлын давалгаа хийгээд төрийн үндэстний бодлогын хатууралт зөөлрөлтийн улмаас буураад дахин өрнөж байгаа ажээ. «Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан» сэтгүүлийн 1987 оны 4 дүгээрт: «...хэт зүүний хэлбэрэл нь мөн манай орны монгол түүх судлалд нөлөөлсөөр

\*Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, дэд доктор